



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/114

Мандалговь

Г Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2014 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Мандалговь хотын гудамжны иж бүрэн хяналтын системийн ажлыг шалгах мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг хамруулсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Ууганбаяр	/Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга/
Нарийн бичгийн дарга:	С.Цэнгэлмаа	/Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн/
Гишүүд:	Э.Мөнхчулуун	/ХХҮГ-ын мэдээлэл, технологийн ажилтан/
	Г.Адъяадорж	/ЭМГ-ын мэдээлэл, технологийн ажилтан/
	Э.Сүхбат	/Монголын цахилгаан холбоо ТӨХК Дундговь аймаг дахь салбарын инженер/

Хоёр. Аймгийн төвд хийгдсэн 62 ширхэг хяналтын камерыг газар дээр нь үзэж, бичиг баримттай танилцаж, төсвийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, аймгийн Засаг даргад тайланг танилцуулахыг ажлын хэсэг /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/495 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0230372